ЗАХИАЛАГЧ:

ӨМНӨГОВЬ АЙМАГ

ЗӨВЛӨХ:

“АВАРГА ЗАМ” ХХК

Шифр AVZ/DZ/02-2019

ЭЦСИЙН ТАЙЛАН

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЗАДГАД СУМЫН ТӨВИЙН АВТО ЗАМ,
ЗОГСООЛЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ

УЛААНБААТАР ХОТ
"АВАРГА ЗАМ" ХХК
DESIGN and CONSULTING SERVICE OF ROAD
1119278553 2729377

ЗАХИРАЛ Г. ЧИНТӨГС

УЛААНБААТАР. 2019 ОН

АГУУЛГА

БҮЛЭГ 1: ҮНДЭСЛЭЛ 3
БҮЛЭГ 2: ЗӨВЛӨХИЙН БАГ 4
БҮЛЭГ 3: ХЭЭРИЙН ХЭМЖИЛТ, БАЙР ЗҮЙН ЗУРАГЛАЛ 5
БҮЛЭГ 4: ИНЖЕНЕР-ГЕОДЕЗИЙН "ГЕО-ҮНДЭС" ХХК-ИЙН ТОВЧ ТАЙЛАН 11
5.1. Байр зүйн зураглалын хээрийн хэмжилт 11
5.2. Суурин боловсруулалтын ажил 12
БҮЛЭГ 6: ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН "ЭНХ-ӨРНӨЛТ" ХХК-ИЙН ТОВЧ ТАЙЛАН 14
6.1. Судалгааны аргачлал 14
6.2. Геологийн тогтоц 14
6.3. Геоморфологи, гидрогеологийн нөхцөл 14
6.4. Уур амьсгал 15
6.5. Талбайн инженер-геологийн нөхцөл, хөрсний физик-механик шинж чанар: 17
6.6. Товч дүгнэлт 23
БҮЛЭГ 7: АВТО ЗАМ ТӨСӨЛЛӨЛТ 25
7.1. Стандарт норм: 25
7.2. Авто зам талбайн төлөвлөлт: 25
7.3. Зам, талбайн байршил, трасс 26
7.3.1. Авто замууд: 26
7.3.2. Зогсоолын талбай: 33
7.4. Хучилтын бүтээц. 46
7.5. Дагуу болон хөндлөн огтлол төсөллөлт: 49
БҮЛЭГ 8: АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ, ТӨСӨВ 51
БҮЛЭГ 9: ГАДАРГУУГИЙН УС ЗАЙЛУУЛАЛТ 51
БҮЛЭГ 10: ГАРЦ УУЛЗВАР 51
БҮЛЭГ 11: ЗАМЫН ТОНОГЛОЛ 51
БҮЛЭГ 12: АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ АРГАЧЛАЛ 53
12.1. Танилцуулга 53
12.2. Барилгын бэлтгэл ажил 53
12.3. Төслийн хэрэгжилт буюу зам барилгын ажил 53
12.4. Барилгын ажлын төлөвлөгөө 54
БҮЛЭГ 13: ЗАСВАР АРЧЛАЛТ 55
13.1. Ерөнхий 55
13.2. Асфальтобетон хучилттай замын засвар арчлалт 55
13.3. Ус зайлуулах байгууламжийн засвар 55
БҮЛЭГ 14: ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ 56
БҮЛЭГ 15: ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ 56
БҮЛЭГ 16: САНАМЖ 57

БҮЛЭГ 1: ҮНДЭСЛЭЛ

"Аварга зам" ХХК нь дараах материалуудыг үндэслэн Өмнөговь аймгийн Даланзадгад сумын төвийн авто зам, зогсоолын ажлын зураг төслийг боловсруулав.

Үүнд:

- Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны "Бид хамтдаа" хөтөлбөр
- Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэл
- Өмнөговь аймгийн төв Даланзадгад сумын 2015-2030 оны хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө
- Өмнөговь аймгийн ЗДТГ-ын даргын 2018 оны 10-р сарын 22-нд батлсан ЗТ-32/2018 тоот "Өмнөговь аймгийн Даланзадгад сумын төвийн авто зам, зогсоолын ажлын зураг, төсөв боловсруулах" даалгавар
- Өмнөговь аймгийн ЗДТГ болон Авто зам, гүүр, аэродромын зураг төслийн Зөвлөх "Аварга зам" ХХК -ий хооронд 2019 оны 4-р сарын 08-ны өдөр байгуулсан ӨМАОНӨГ/201810241 тоот "Зураг төсөл боловсруулах ажил"-ын гэрээ
- 2019 оны 4-р сард хийсэн инженер-геодезийн хэмжилт, зураглал, тайлан
- 2019 оны 4-р сард хийсэн инженер-геологийн судалгаа, тайлан
- "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016
- "Хот суурины гудамж зам төсөллөх" БНбД 32-01-04
- "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНбД 32-02-03
- "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" АЗУАГН 2.01.01-2004
- Бусад зураг төсөл зохиох норм ба стандартууд

Ашигласан программ хангамж:

1. Авто замын төлөвлөлтийн "IndorCAD/Road-9" программ
2. Авто замын хучлагын тооцооны "Indor Pavement -9 Expert" программ
3. Авто замын төсөв зохиох "RBC-Estimator" программ

Зураг төслийн иж бүрдэл:

- Тайлбар бичиг
- Техникийн шаардлага
- Инженерийн нарийвчилсан зураг - 1-р дэвтэр
- Инженерийн нарийвчилсан зураг - 2-р дэвтэр
- Инженер-геологийн тайлан
- Инженер-геодези, байр зүйн зураглалын тайлан
- Борооны ус зайлуулах шугамын ажлын зураг
- Гэрэлтүүлэгийн ажлын зураг
- Зам талбайн барилгын ажлын Хяналтын төсөв.
- Борооны ус зайлуулах байгууламжийн төсөв
- Гэрэлтүүлгийн төсөв

БҮЛЭГ 1: ҮНДЭСЛЭЛ

“Аварга зам” ХХК нь дараах материалуудыг үндэслэн Өмнөговь аймгийн Даланзадгад сумын төвийн авто зам, зогсоолын ажлын зураг төслийг боловсруулав.

Үүнд:

- Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны “Бид хамтдаа” хөтөлбөр
- Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэл
- Өмнөговь аймгийн төв Даланзадгад сумын 2015-2030 оны хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө
- Өмнөговь аймгийн ЗДТГ-ын даргын 2018 оны 10-р сарын 22-нд баталсан ЗТ-32/2018 тоот “Өмнөговь аймгийн Даланзадгад сумын төвийн авто зам, зогсоолын ажлын зураг, төсөв боловсруулах” даалгавар
- Өмнөговь аймгийн ЗДТГ болон Авто зам, гүүр, аэродромын зураг төслийн Зөвлөх “Аварга зам” ХХК -ий хооронд 2019 оны 4-р сарын 08-ны өдөр байгуулсан ӨМАОНӨГ/201810241 тоот “Зураг төсөл боловсруулах ажил”-ын гэрээ
- 2019 оны 4-р сард хийсэн инженер-геодезийн хэмжилт, зураглал, тайлан
- 2019 оны 4-р сард хийсэн инженер-геологийн судалгаа, тайлан
- “Авто зам төсөллөх” ЗЗБНбД 22-004-2016
- “Хот суурины гудамж зам төсөллөх” БНбД 32-01-04
- “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНбД 32-02-03
- “Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл” АЗУАГН 2.01.01-2004
- Бусад зураг төсөл зохиох норм ба стандартууд

Ашигласан программ хангамж:

1. Авто замын төлөвлөлтийн “IndorCAD/Road-9” программ
2. Авто замын хучлагын тооцооны “Indor Pavement -9 Expert” программ
3. Авто замын төсөв зохиох “RBC-Estimator” программ

Зураг төслийн иж бүрдэл:

- Тайлбар бичиг
- Техникийн шаардлага
- Инженерийн нарийвчилсан зураг - 1-р дэвтэр
- Инженерийн нарийвчилсан зураг - 2-р дэвтэр
- Инженер-геологийн тайлан
- Инженер-геодези, байр зүйн зураглалын тайлан
- Борооны ус зайлуулах шугамын ажлын зураг
- Гэрэлтүүлэгийн ажлын зураг
- Зам талбайн барилгын ажлын Хяналтын төсөв.
- Борооны ус зайлуулах байгууламжийн төсөв
- Гэрэлтүүлгийн төсөв

БҮЛЭГ 2: ЗӨВЛӨХИЙН БАГ

Зөвлөх компаний багийн бүрэлдэхүүн:

- Ерөнхий гүйцэтгэгч: “**Аварга зам**” ХХК,
- Туслан гүйцэтгэгч инженер-геодези, байр зүйн зураглалын “**Гео-Үндэс**” ХХК болон “Аварга зам” ХХК-ийн геодезийн хэсэг
- Туслан гүйцэтгэгч инженер-геологи, материалын судалгааны “**Энх-Өрнөлт**” ХХК
- Барооны ус зайлуулах байгууламжийн зураг төслийн “**Гидрофонтан**” ХХК
- Гэрэлтүүлгийн зураг төслийн “**Арбэл-Алтай**” ХХК

Зөвлөхийн багийн мэргэжилтний жагсаалтыг хүснэгт 2-1-ээр үзүүлэв. *Хүснэгт 2-1*

Багийн ахлагч У. Пүрэвжав Монгол улсын Зөвлөх инженер, ТУ-ны Доктор, Профессор			
№	Нэрс	Албан тушаал	Компанийн нэр
Авто замын хайгуул, зураг төслийн хэсэг			
1.	Г.Чинтөгс	Авто зам төлөвлөлтийн Мэргэшсэн инженер, ТУ-магистр	“Аварга зам” ХХК
2.	С.Батсүх	Авто зам төлөвлөлтийн Мэргэшсэн инженер, Мэргэшсэн төсөвчин	“Аварга зам” ХХК
3.	М.Мөнх-Оргил	Гүүр хоолойн Мэргэшсэн инженер, ТУ-ын магистр	“Аварга зам” ХХК
4.	М. Бямбаа	Авто замын Мэргэшсэн инженер	“Аварга зам” ХХК
5.	П. Энхбаяр	Авто замын Мэргэшсэн инженер	“Аварга зам” ХХК
6.	С. Цэрэннадимд	Техникч, жолооч	“Аварга зам” ХХК
Инженер-геодези, байр зүйн зураглалын хэсэг			
1.	М.Намхайдорж	Геодезийн Мэргэшсэн инженер	“Гео-Үндэс” ХХК
2.	Н. Ариунзаяа	Геодезийн мэргэшсэн инженер	“Аварга зам” ХХК
3.	Д. Ундармаа	Геодезийн Мэргэшсэн инженер, ТУ-ны магистр	“Гео-Үндэс” ХХК
4.	Г. Батхолбоо	Геодезийн инженер	“Аварга зам” ХХК
Инженер-геологи, материалын судалгааны хэсэг			
1.	Ч. Баатар	Инженер-геологийн Зөвлөх инженер	“Энх-Өрнөлт” ХХК
2.	Б. Мөнхбадрах	Инженер-геологич, материалын инженер	“Энх-Өрнөлт” ХХК
3.	Ё. Ариунаа	Инженер-геологич	“Энх-Өрнөлт” ХХК
4.	Б. Ганбилэг	Авто замын Материалын инженер	“Аварга зам” ХХК
5.	Б. Азжаргал	Өрмийн мастер	“Энх-Өрнөлт” ХХК
Барооны ус зайлуулах байгууламжийн зураг төслийн хэсэг			
1.	Хорлий	Усны барилга байгууламжийн Зөвлөх инженер	“Гидрофонтан” ХХК
2.	Нэргүй	Усны барилга байгууламжийн инженер	“Гидрофонтан” ХХК
Гэрэлтүүлэг, холбооны зураг төслийн хэсэг			
1.	Хажидсүрэн	Цахилгааны инженер	“Арбэл-Алтай” ХХК

2.	Майцэцэг	Цахилгааны инженер	“Арбэл-Алтай” ХХК
3.	Солонго	Холбооны инженер	“Арбэл-Алтай” ХХК

БҮЛЭГ 3: ХЭЭРИЙН ХЭМЖИЛТ, БАЙР ЗҮЙН ЗУРАГЛАЛ

Ажлын даалгаварт заасан төслийн авто зам, зогсоолын талбайн байршлыг Өмнөговь аймгийн Ерөнхий архитектор Ц. Золбоо, Даланзадгад сумын газрын даамал нартай хамтран газар дээр явж үзсэн. Түүнчлэн ажлын даалгаварт заасан обьектыг өөр обьектоор солих асуудлыг ерөнхий архитектор аймаг, сумын удирдлагуудтай ярилцаж шийдвэрлэсэн.

Зөвлөхийн баг хайгуулын хэмжилт, судалгааны ажлаа 2019 оны 4-р сарын 9-өөс эхэлсэн.

Ажлын талбайд хийгдсэн ажлын гүйцэтгэлийг доорхи хүснэгт 3-1-ээр үзүүлэв.

Хүснэгт 3-1

Д/д	Гүйцэтгэсэн ажлын нэр төрөл, дараалал	Хэмжих нэгж	Хийгдсэн ажил
1.	Замын трассын сонголт ба урьдчилсан хайгуул судалгаа	м м2	2700 26140
2.	Замын трассын дагууд нарийвчилсан тэмдэглэл хөтлөн зам дагууд тавигдах хиймэл байгууламж болон бусад байгууламжийг нарийвчилан тогтоох судалгаа	м м2	2700 26140
3.	Геодезийн хуучин цэгүүдийн судалгаа, сэргээн босголт	цэг	4
4.	GPS ашиглан статик хэмжилт хийх	цэг	4
5.	Зам, талбайн зурвас хэсгийн 1:2000 –ны зураглал	га	27
6.	1:2000 зураглалын боловсруулалт	га	27
7.	Трассын дагууд болон гүүрийн орчимд цооног өрөмдөх, дээж авах, хээрийн туршилт хийх зэргээр буурь хөрсний инженер геологийн судалгаа */өрөмдөгийн тоогоор/*	ш	25
8.	Зам барилгын ажилд хэрэглэгдэх материалын шинжилгээ, байрлал, нөөцийг тодруулах материалын судалгаа шинжилгээ		Орон нутгийн зөвшөөрөгдсөн карьер, шороон ордыг ашиглана.

Дээрх ажлуудыг холбогдох техникийн шаардлага, заавар зөвлөмж, норм дүрм стандартыг баримтлан гүйцэтгэсэн болно.

Зураг 3-1.

Apr 13, 2019 11:21:52
48N 4824561 453133
Зр сургууль

Нутгийн удирдлагын ордны арын зогсоолын талбай

Apr 13, 2019 12:24:35
48N 4826107 453627
Хөгжим драмын театрын зогсоол

Apr 13, 2019 12:00:04
48N 4825319 453407
Авто тээврийн урд зогсоол


Apr 13, 2019 12:38:53
48N 4824651 454328
Unnamed Road
Dalandzadagad
Khankhongor
Ömnögovi
БОЭТ зогсоол

Apr 13, 2019 12:08:52
48N 4826081 453889
5р сургууль зүүн зогсоол


Apr 13, 2019 11:35:33
48N 4824788 453396
24р цэцэрлэгийн зогсоол

Apr 13, 2019 13:01:53
48N 4823241 454252
Dalanzadgad
давуулах далан

БҮЛЭГ 4: ИНЖЕНЕР-ГЕОДЕЗИЙН “ГЕО-ҮНДЭС” ХХК-ИЙН ТОВЧ ТАЙЛАН

“Даланзадгад сумын төвийн авто зам, зогсоолын зураг төсөл боловсруулах” ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Даланзадгад сумын төвийн авто зам зогсоолын 1:500-ны масштабтай 0.5 метрийн үеийн өндөртэй байр зүйн зураглалыг Захиалагчийн техникийн шаардлагын дагуу тоон хэлбэрээр хийж гүйцэтгэв.

1:500-ны масштабтай байр зүйн зураглалын хээрийн хэмжилтийн ажлыг тус компанийн ахлах инженер М.Намхайдорж ахлагчтай 5 хүний бүрэлдэхүүнтэй бригад 2019 оны 04 дүгээр сарын 10-наас 04 дүгээр сарын 17-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв. Гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээг хүснэгт 1-д үзүүлэв. Ажлын талбайн ерөнхий бүдүүвчийг Хавсралт 1-д үзүүлэв.Уг ажлын хүрээнд гүйцэтгэсэн ажлын хэмжээг доор үзүүлэв. Үүнд:

Хүснэгт 1

Д/д	Гүйцэтгэсэн ажлын нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ
1	Геодезийн хуучин цэгийн судалгаа	цэг	4
2	1:500-ны масштабтай зураглал	га	26.89 га
3	1:500-ны масштабтай зураглалын боловсруулалт	га	26.89 га

Уг ажлыг доорхи техникийн шаардлага, заавар, стандартыг баримтлан гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. 1:500, 1:1 000, 1: 2 000, 1: 5 000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил БД 11-106-08
2. Барилгын геодезийн ажил БНбД 11-08-06
3. Авто зам болон төмөр замын геодезийн ажил БД 11-114-14
4. Барилга байгууламжийн инженерийн нийтлэг үндэслэл БНбД 11-07-04
5. Геодезийн цэг тэмдэгтийн ажил БД 11-104-06
6. Байр зүйн зургийн томьёолсон тэмдэг масштаб 1:5000, 1:2000, 1:1000, 1:500 ,2011 он
7. Том, дунд масштабтай байр зүйн зураглалд ашиглах Дэлхийн хөндлөн меркатор UTM тусгагийн параметр
8. Геодези, байр зүйн ажлын техникийн тайлан бичих заавар, 1985

5.1. Байр зүйн зураглалын хээрийн хэмжилт

Тус суманд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажлын хүрээнд 2014 онд “Аэрогеодези”ХХК-ийн гүйцэтгэсэн үндэслэлийн сүлжээний 15 цэг байгаа учир дахин нэмж шинээр цэг суулгах шаардлагагүй ба тус цэгүүдээс тулгуурлан байр зүйн зураглал гүйцэтгэх боломжтой юм.

Судалгаанд хамрагдсан устаж гэмтээгүй, хэмжилт хийх нөхцөл нь алдагдаагүй цаашид ашиглах цэгийн нэр дугаар, хол ойрын гэрэл зураг, орчны тойм зураг, зай хэмжээсийн байдал, байршлын тухай тэмдэглэл, судалсан огноо зэрэг мэдээллийг багтаасан хувийн хэргийг Хавсралт 2-д үзүүлэв. ГХГЗЗГ-аас баталгаажуулж авсан албан ёсны геодезийн солбицол, өндрийн утгыг Хавсралт 3-д хавсаргав.

Судалсан цэгийн солбицол, өндрийн жагсаалтыг Хүснэгт 2-д үзүүлэв.Хүснэт 4-1

Д/д	Цэгийн дугаар	Солбицол-UTM48N		Өндөр
		X	Y	
GPS-ийн сүлжээний цэгүүд				
1	ГР-0011	4826158.668	453646.509	1452.727
2	ГЦТ-41-115	4824724.994	454485.335	1459.769
3	ГХГЗЗГ-6093	4824738.965	450827.228	1486.023
4	ГХГЗЗГ-6098	4823021.760	454312.860	1478.729

3.2 1:500 ны масштабтай байр зүйн зураглал

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын төвийн авто зам, зогсоолын зураг төсөл боловсруулах ажлын 1:500-ны масштабтай байр зүйн зураглалыг “1:5000, 1:2000, 1:1000, 1:500-ны масштабтай байр зүйн зураглалын ажлын заавар” /ГЗНД 01.85.03/-ыг баримтлан 2 долгионы HIPER II G маркийн GPS ашиглан, Даланзадгад сумын геодезийн үндэслэлийн цэг болох Гр-11, ГЦТ41-115, ГХГЗЗГ-6093, ГХГЗЗГ-6098 дугаартай цэгүүдээс тулгуурлан, RTK хэмжилтийн аргаар байрлалын хувьд UTM-48N/WGS84/ солбицлын системд, өндрийн хувьд Балтийн тэнгисийн өндрийн тогтолцоонд тус тус үйлдсэн болно.

Байр зүйн зураг үзүүлэх шаардлагатай :

- Бүх төрлийн барилга байгууламжийг хэмжиж тодруулж зураг оруулахдаа тухайн барилгын хийц материалаас шалтгаалан чулуу, тоосго, төмөр, модон гэж ангилан хэдэн давхар байгааг, мөн зориулалтаар нь тодоруулж зохих масштабын дагуу оруулж өгөв.

- Шинээр тавигдсан авто зам, төмөр зам түүний байгууламж буюу ус зайлуулах хоолой, гүүр, нүхэн гарц, далангийн хэмжилтийг хийн авто замыг дотор нь хатуу хучилттай , ердийн хөрсөн, сайжруулсан зам гэж ангилан тодруулж зураг оруулж өгөв.

- Газар доорхи болон газар дээрх инженерийн шугам сүлжээний хэмжилт тодруулалтыг суурин газраас гарч байгаа хэсгээс нь эхэлж төгсгөл хүртэл нь хэмжиж зураг оруулж өгсөн.

- Газар дээр тодорхой орон зай эзэлж байгаа трансформатор, граж, хөшөөний

цогцолбор, зоорь, оршуулгын газар, ус түгээх байр, усан ориглуур зэргийг хэмжиж тусгайлан таних тэмдгээр оруулж өгөв.

- Газрын гадаргын элементүүд, зам талбай,гарц хоолой, ус зүй түүний барилга байгууламж, жалга, элс, дэрс, дов намагны контур, нүх болон овоолсон шороо, шороон далан, суваг шуудуу болон бусад объектууд зэргийг зохих нарийвчлалаар хэмжиж кодлон хэмжилтийн багажны дотоод санах ойд хадгалан, дараа нь хадгалсан хээрийн хэмжилтийн өгөгдлийг текст хэлбэрээр мөн Mobile divice программын тусламжтайгаар компьютерт шилжүүлж авсан болно.

Авто зам, зогсоолын байр зүйн зураглалын ажлыг захиалагчаас гаргаж өгсөн хил хязгаар дотор буюу нийт 14 хэсэгт нийт 268915.25 мкв буюу 26.89 га талбайд гүйцэтгэлээ.

5.2. Суурин боловсруулалтын ажил

Суурин боловсруулалтын ажилд “AutoCAD Civil3D 2019”, “AutoCAD Land 2009” программуудыг ашигласан бөгөөд AutoCAD-ын (dwg) форматаар, тоон байдлаар бэлтгэлээ. Хаялбарын үеийн өндрийг 0.5 метрээр татав.

Зураглалын таних тэмдгийг байр зүйн зургийн томьёолсон тэмдэгийн масштаб 1:5000, 1:2000, 1:1000, 1:500 ,2011 он -г ашиглан дараах гадаргуудыг үүсгэн боловсрууллаа.

Авто зам, зогсоолын байр зүйн зураглалын ажлыг захиалагчаас гаргаж өгсөн хил хязгаар дотор буюу нийт 14 хэсэгт нийт 268915.25 мкв буюу 26.89 га талбайд гүйцэтгэлээ. Зураглал гүйцэтгэсэн байршил болон талбайн хэмжээг Хүснэгт 3-р үзүүлэв.

Хүснэт 4-2

Д/д	Зураглал гүйцэтгэсэн байршил	Зураглал гүйцэтгэсэн талбайн хэмжээ, Мкв
1	25-р цэцэрлэг- зогсоол	53021.30
2	5-р сургууль- зогсоол	
3	ХЖТ- зогсоол	
4	Авто тээвэр- зогсоол	4576.32
5	3-р сургууль- авто зам	11846.29
6	24-р цэцэрлэг- авто зогсоол	10530.39
7	Нутгийн зөвлөлийн удирдлагын ордон-авто зогсоол	13154.50
8	1-р цэцэрлэг-авто зогсоол	
9	БОЭТ- авто зогсоол	6052.55
10	ХУД.Төв- авто зогсоол	8639.50
11	Гаалийн хороо-авто зам	17621.53
12	23-р цэцэрлэг-авто зогсоол	24103.34
13	Давуулах далан	11738.26
14	Дугуйн зам-авто зам	107631.27
Нийт		**268915.25= 26.89га**

БҮЛЭГ 6: ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН “ЭНХ-ӨРНӨЛТ” ХХК-ИЙН ТОВЧ ТАЙЛАН

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын төвийн автозам, дугуйн зам, авто зогсоолын талбайн зураг төсөл боловсруулахад зориулсан инженер-геологийн судалгааг Барилгын инженер-геологийн “Энх-Өрнөлт” ХХК –аас 2019 оны 4-р сарын 16-наас 5-р сарын 21-ны өдөр хүртэл хээрийн судалгаа, лабораторийн шинжилгээ, суурин боловсруулалтын гэсэн 3 үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ.

6.1. Судалгааны аргачлал

Судалгааны талбайн инженер-геологийн хээрийн судалгааны ажлыг инженер-геологич Б.Мөнхбадрахын удирдлагаар өрмийн мастер Ү.Давгасүмбэрэл, А.Тамир нарын бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэв. Хээрийн судалгааны ажлыг явуулахдаа Монгол орны нутаг дэвсгэрт шугаман байгууламжийн инженер-геологийн судалгаа хийх заавар. БД 11-107-10-ийн заалтыг үндэслэл болгосон бөгөөд өрмийн УГБ-50М төхөөрөмжөөр, ус давуулах далангийн хэсэгт 6,0 метрийн гүнтэй 1 цооног, зам талбайн зогсоол болон дугуйн замын трассын дагууд дээжлэлттэйгээр 2.0-3,0 метрийн гүнтэй хайгуулын 25 цооногийг /Нийт 76.0 т/м/, баганат өрөмдлөгийн аргаар өрөмдөв. /Малталтын байршлын зураг үз/

Өрөмдлөг судалгааны ажлын үр дүнд талбайд тархсан хөрсний тархалт, нэр төрлийг тогтоож, лабораторийн шинжилгээнд зориулан 20 ш дээж авч “Энх-Өрнөлт” ХХК-ийн хөрс судлалын лабораторид ул хөрсний ангиллыг MNS 3263:2014-ээр ангилж, физик шинж чанарыг MNS 2143-2004-ын дагуу лаборант А.Тунгалаг хийлээ. Мөн материалын карьерт зориулж хайрганы 1, чулууны 1 дээж авч Зам тээврийн хөгжлийн төв зам барилгын эрдэм шинжилгээ, судалгааны итгэмжлэгдсэн төв лабораторид шинжилгээ хийлгэсэн. Чулууны элэгдэх чанарыг MNS ASTM C535-2003 стандартын дагуу, далан суурийн материалыг MNS ASTMD1883-2002 стандартуудын дагуу тус тус хийсэн. Лабораторийн шинжилгээний үр дүн, хээрийн судалгааны материалуудыг нэгтгэн боловсруулж, энэхүү дүгнэлтийг ажлын зураг төсөл зохиоход зориулан инженер-геологич Ё.Ариунаа бичлээ. Судалгааны ажилд захиалагчаас ирүүлсэн 1:1000 болон 1:4000 масштабтай схем зургийг ашиглан өрөмдсөн цооногуудыг зурагт тэмдэглэж амсрын өндөржилтийг тогтоолоо.

6.2. Геологийн тогтоц

Геологийн тогтоцын хувьд судлаж буй район нь нилээд нийлмэл тогтоцтой юм. Тухайлбал Даланзадгад хотын орчимд девон, чулуун нүүрс, цэрд, гуравдагч ба дөрөвдөгч галавын алевролит, туф болон өнгө өнгийн зосон түрхээст сэвсгэр хурдас зонхилон тархсан. Судалгааны трассын дагуух талбайд орчин үеийн дунд-дээд дөрөвдөгчийн настай нуур-пролювийн гаралтай хайрга агуулсан шавранцар, хайргархаг шавранцар, шавранцараар чигжигдсэн хайрга, хайрга агуулсан шавар зэрэг шаварлаг хөрсүүд үелэн тархсан байна.

6.3. Геоморфологи, гидрогеологийн нөхцөл

Судалгааны район нь геоморфологийн ерөнхий ангилалын хувьд Монгол ба Говь-Алтайн уулст тогтолцоо, уулс хоорондын тууш хотгор бүхий муж буюу Дундговь-Өмнөговийн мужийн Мандал-Овоо, Манлайн дэд мужид багтана. Судалгаа явуулсан талбай нь хотгор гүдгэрийн хэв шинжийн байдлаар тектоник элэгдэл (говь маягийн нам уулс, нам уул, тасархай уул) тектоник хуримтлалын (хонхор, хотос, гүдэн, тов толгод) гадарга ялгарна. Даланзадгад хот байрладаг талбай нь Зүүн-Сайхан уулын хормойг түшсэн гүдэн хотос бүхий баруун өмнөөсөө зүүн хойшоогоо налуу гадаргатай.

Гидрогеологийн ангилалаар улирлын хомс тэжээлтэй муж буюу Дорноговийн дэд мужид багтана. Гидрологийн хувьд тус нутаг нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтах ба Даланзадгад хотын гидрогеологийн нөхцөл нь Монгол орны гидрогеологийн мужлалаар нууруудын хөндийн районд хамаарагдаж байгаа бөгөөд энд аллюви, пролюви, нуурын сэвсгэр хурдасны болон ан цавлаг чулуулгийн ус тархжээ.

Судалгааны талбайн хэмжээнд тогтмол урсацтай гадаргын ус тун ховор юм. Зөвхөн делюви-пролювийн хурдаснаас гарсан булгуудын ус хотын баруун урд хэсгээр хуримтлагдаж жижиг хэмжээний нуур намагжсан талбай үүссэн байх нь ажиглагдана. Зүүн-Сайхан уулын бэлээс буусан

хуурай сайраар хур тунадас ихтэй жилд түр зуурын урсгал усны урсац бий болж тэр ус нь улмаар хотын зүүн хэсгийг намагжуулж аажмаар хурдсанд шингэнэ. Аймгийн төв хэсгээр баруунаас зүүн тийш чиглэлтэй олон тооны жижиг салаа хуурай сайр элбэг байна.

Судлагдсан трассын дагуух инженер-геологийн судалгаанд зориулж 2,0-6,0 метрийн гүнтэй 26 цооног өрөмдөхөд сумын төвийн урд хэсэгт өрөмдсөн цооног № 9-д хөрсний ус 5,0 метрийн гүнд илэрсэн байна.

Хөрсний ус нь гадаргын хур тунадасны усаар тэжээгддэг чөлөөт гадаргатай бөгөөд тэжээгдлээсээ хамаарч түвшин нь улирлаар хэлбэлзэнэ. Хөрсний усны түвшин хамгийн ихээр дээшлэн тогтох үе нь намар 9-10-дугаар сард, хамгийн доошлох үе нь хавар 3-4 –дүгээр сард байна.

Судалгаа хийсэн энэ үе нь хөрсний усны түвшин хамгийн ихээр доошилсон үе болно. Хөрсний усны улирлаар хэлбэлзэн дээшлэн тогтох түвшинг өмнөх судлагдсан байдлыг харгалзан одоогийн тогтсон түвшингээс 1,0 метрээр дээшлэн тогтохоор тооцож инженер-геологийн зүсэлтэнд тэмдэглэн үзүүлэв.

Хөрсний усны химийн шинжилгээний дүнг өмнөх судалгааны материал [5] -иас тооцож өглөө. Химийн шинжилгээний үр дүнгээр хөрсний ус нь өнгө, үнэр, амтгүй тунгалаг, гидрокарбонат, сульфат, кальци, натрийн төрлийн ус болно. Усны химийн найрлагыг Курловын томьёогоор илэрхийлбэл:

$$M_{0.7}\ \underline{HCO_3\text{-}50.5\ SO_4\text{-}28.7}\quad PH\text{-}7.55$$

$$Ca\text{-}47.3\ Na\text{-}35.5$$

бөгөөд бетон эдлэлд идэмхий чанар үзүүлэхгүй байна. Хөрсний усны найрлага нь голдуу цэнгэг гидрокарбонат кальцийн ус болно. [5]

6.4. Уур амьсгал

Судлагдсан талбай нь Монгол орны зам-уур амьсгалын бүсчлэлээр III А –говийн дэд бүсэд хамаарах бөгөөд бусад нутаг дэвсгэрийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай. Энэ бүсийн онцлог нь Авто замын уур амьсгалын нэн хуурай дулаан, хүйтэн хүйтэвтэр хахирлаг говийн цөлжүү хээр, заримдаг газрууд юм. Мөн уур амьсгалын хүчтэй салхи шороон шуургатай, халуун бүгчим, хуурай онцлогтой. Энэ бүсийн зарим онцлог үзүүлэлтүүдийг доорхи байдлаар үзүүлэв. /АЗУАГН.01.01-2004/

Улирлын үргэлжлэх хугацаа Хүснэгт №6-1

Дэд бүс	Өвөл			Хавар		Зун		Намар
	Эхлэх	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Үргэлжлэх хоног
IIIA	2-15XI 9.XI	9-24.III 16.Y	126-146 136	25.IY-25.Y 1.Y	35-55 45	25.IX-1.X 28.IX	145-159 152	42-46 44

Тайлбар:

* өвлийн дуусах хугацаа хаврын эхлэл, хаврынх зуны эхлэл, зуных намрын эхлэл, өвлийн эхлэл намрын дуусах хугацаа болно.

Хөрс, агаарын температурын (°C) үзүүлэлт Хүснэгт №6-2

Дэд бүс	Хөрсний гадаргын температур, °C				Агаар орчны дундаж температур		
	Олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	0° нэвчих гүн, см*	Олон жилийн дундаж	Хамгийн хүйтэн сарын	Хамгийн дулаан сарын
IIIA	+3...+7	65-70	-39...-42	200-300	+2...+6	-15...-20	20...25

Тайлбар:

* -0^{0}С нэвчих гүн ул хөрсний төрлөөс хамаарах тул дээд, доод хязгаарыг авав.

Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа Хүснэгт №6-3

Дэд бүс	Хөлдөлт			Гэсэлт		
	Эхлэх	Дуусах	Хоног	Эхлэх	Дуусах	Хоног
IIIA	1-10,XI 25.X	25.II-15.III 5.III	110-120 115	20.II-15.III 2.III	1-15.IV 7.IV	10-20 35

Авто замын барилгын үйлдвэрлэлийн ажил явуулахад

тохиромжтой болон тохиромжгүй улирлын үеүүд Хүснэгт №6-4

Дэд бүс	Дулааны улирал *			Хүйтний улирал
	Эхлэх	Дуусах	Хоног	Хоног
IIIA	20.III	25.X	228	137

Тайлбар: - Авто замын барилгын үйлдвэрлэлийн хүйтний улирлын эх нь дулааны улирлын төгсгөл, хүйтэн улирлын төгсгөл нь дулааны улирлын эх болдог

Авто замын уур амьсгалын жилийн 4 улирлын салхины хурд,

агаарын даралт, харьцангуй чийгшил Хүснэгт №6-5

Дэд бүс	Салхины хурд, м/с				Даралт, мм Hg баганын өндрөөр	Харьцангуй чийгшил, %
	Өвөл	Хавар	Зун	Намар		
IIIA	2.5-4.0	3-6	2-5	2.5-4.5	650-700	40-60

Хээр гадаа ажиллах авто замын ажилчдын

хөдөлмөрийн био уур амьсгалын нөхцөл Хүснэгт №6-6

Дэд бүс	Хүчилтөрөг-чийн нягт, г/см^3	Хувцас хунарын дулаан чанар, КЛО (хүндэвтэр ажлыг нөхцлөөр тооцов)			Уур амьсгал хүний биед, хоног		
		өвлийн	Хавар, намрын	Зуны	Таатай	Цочроох	Хурц
IIIA	250-225	4-4.5	2.5-3.0	1-1.3	180-195	120-135	20-30

Авто замын үйлдвэрлэл, замчдын хөдөлмөрт

уур амьсгалын нөлөөллийг үнэлэх итгэлцүүрүүд Хүснэгт №6-7

Дэд бүс	Нөлөө үйлчлэлийн итгэлцүүр				
	Хүйтний	Хахирын	Халууны	Хур тунадасны	Чийгшлийн
IIIA	0.90	1.07	1.14	0.64	0.95

Авто замын уур амьсгалын бүсүүдэд халуун асфальт бетон

хольц бэлтгэж дэвсэхэд тохиромжтой хугацаа Хүснэгт №6-8

Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
	Эхлэх	Дуусгах	Хоног

IIIA	9.IY-2.V (20.IV)	5.IX-2.X (18.IX)	129-176 (151)

Авто замын уур амьсгалын бүсүүдэд хүйтэн, бүлээн

асфальт бетон хучилт хийхэд тохиромжтой хугацаа Хүснэгт №6-9

Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
	Эхлэх	Дуусгах	Хоног
IIIA	23.II-15.III (5.III)	12.IX-11.XII (27.XI)	244-301 (267)

Өмнөговь аймгийн Даланзадгад цаг уурын станцын олон жилийн ажиглалтын үзүүлэлтүүдийг БНбД-23-01-09, БНбД 2.01.01-93/2001, -ын дагуу үзүүлбэл:

Зураг төсөлд хэрэглэх уур амьсгал ба геофизикийн

үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулбал: /*БНбД.2.01.01-93.2001/*

Хүснэгт №6-10

Аймаг хот, тосгон суурин, дүүргийн нэр	Хоногийн дундаж температурын хазайлт ^{0}C	Салхины даралтын нормчилсан утга q		Хамгийн хүйтэн 3 сарын салхины дундаж хурд м/с	Хэвтээ гадарга дээрх цасны ачааллын нормчилсан утга	
		кг/м^2	ГПа		кг/м^2	гПа
Даланзадгад	12,5	60	0,60	2,6	0.3	30

Гадаргын сар, жилийн дундаж температур */БНбД-23-01-09/* Хүснэгт №6-11

Сар t^{0}C	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Даланзадгад	-14,8	-10,9	-2,9	6,4	14,0	19,6	21,6	19,8	13,5	5,0	-5,3	-12,9	4,6

Салхины жилийн дундаж хурд : */Даланзадгад/*- 3,6 м/сек,

Өвлийн сарын дундаж хурд : */Даланзадгад/*- 2.7 м/сек

6.5. Талбайн инженер-геологийн нөхцөл, хөрсний физик-механик шинж чанар:

Хот төвлөрч байгаа талбайн уулын ар бэлд гулсан хуримтлагдаж тогтсон гүдэн нь хотгор гүдгэрийн ганц элемент бүрдүүлэх ба хуримтлагдсан сэвсгэр хурдас нь нуур-пролювийн гарал үүсэлтэй болно. Геологийн дөрөвдөгч гуравдагч галавт хуримтлагдсан сэвсгэр хурдасны бүлэг гүдэн хэлбэртэйгээр уулын бэлд байрлана. Судлагдсан талбай нь инженер-геологийн дунд зэргийн төвөгтэй нөхцөлтэй. Энэ нь судалгааны талбайн урд хэсэгт хөрсний ус 5,0 метрийн гүнд илэрсэн, трассын дагууд болон зогсоолын талбайд нөлөөлөхүйц физик геологийн үйл явц үзэгдлийн нөлөө бага ч хүчтэй овойлт үүсгэх шаварлаг хөрс тархсан, мөн талбайн угаалт дунд зэрэг явагддаг зэрэг нь инженер-геологийн дунд зэргийн төвөгтэй нөхцөлийг бүрдүүлнэ.

Талбайд хийсэн хээрийн судалгааны материал болон лабораторийн шинжилгээний үр дүнг нэгтгэж инженер-геологийн 4 элемент ялган тус бүрийн физик механик шинж чанарын үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй оруулав.

а*/ **Асгамал хөрс: /Далангийн шороо/***

Дугуйн зам төлөвлөж байгаа хэсэгт 0,9-1,2 метрийн зузаантай тархсан байх ба бусад судлагдсан талбайд 0,2-0,5 метрийн зузаантайгаар шаварлаг ул хөрсний хучиж тогтсон байна. Хатуулгийн зэрэг- III.

б/ *Өнгөн хөрс:*

Зам талбайн зогсоол болон трассын дагуух хэсэгт бор хүрнээс бор шаргал өнгөтэй, хайрганы бага хэмжээний агуулгатай элсэн хөрснөөс тогтсон өнгөн хөрс 0,1-0,2 метрийн зузаантайгаар хучиж тогтсон байна. Өнгөн хөрсийг замын сууриас ухаж зайлуулах ба янз бүрийн хөрс сайжруулах нөхөн сэргээх, карьеруудыг булж тэгшлэх, замын орчны зүлэгжүүлэлт, тохижилтын ажилд ашиглах боломжтой. Хатуулгийн зэрэг-I.

Өнгөн хөрсний дороос илэрсэн үндсэн ул хөрсийг инженер-геологийн элемент (ИГЭ)-д ангилан авч үзлээ.

в/ Хайрга агуулсан шавранцар ул хөрс: /ИГЭ-1/

Бор шаргалаас цайвар саарал өнгөтэй, нуур пролювийн гаралтай, дөрөвдөгчийн настай, хатуу консистенцитэй хайрга агуулсан шавранцар ул хөрс нь судлагдсан талбайн хэмжээнд өнгөн хөрсний дороос эхлэн илэрч тархсан байх бөгөөд зам талбайн зогсоол, трассын ихэнх хэсгээр зонхилон тархсан байна. */Инженер-геологийн зүсэлт үз./*

Энэ хөрсний дээжүүдэд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнгээс үзвэл мөхлөг бүтцийн бүрэлдэхүүнд нь:

- Хайрган хэсэг 19,5%
- Элсэн хэсэг 35,4%
- Тоосорхог хэсэг 26,0%
- Шаварлаг хэсэг 19,1% тус тус агуулагдана.

Хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүд нь:

- Байгалийн чийг 0.113
- Урсалтын хязгаарын чийг 0.270
- Имрэгдлийн хязгаарын чийг 0.166
- Уян налархайн үзүүлэлт 0.104
- Хувийн жин 2.72 г/см^3
- Эзэлхүүн жин 2,04 г/см^3
- Хэлхээдсийн эзэлхүүн жин 1.83 г/см^3
- Сүвшил 32,62%
- Сүвшлийн итгэлцүүр 0.488
- Чийглэгийн зэрэг 0.63
- Консистенц <0

Хайрга агуулсан шавранцар ул хөрсний хатуулгийн зэрэг-II.

г/ Шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрс: /ИГЭ-2/

Бор шаргалаас цайвар саарал өнгөтэй, пролювийн гаралтай, дөрөвдөгчийн настай, хатуу консистенцитэй шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрс */Инженер-геологийн зүсэлт үз./*

Энэ хөрсний дээжүүдэд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнгээс үзвэл мөхлөг бүтцийн бүрэлдэхүүнд нь:

- Хайрган хэсэг 53,1%

- Элсэн хэсэг 21,6%
- Тоосорхог хэсэг 9,7%
- Шаварлаг хэсэг 15,6% тус тус агуулагдана.

Хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүд нь:

- Байгалийн чийг 0.084
- Урсалтын хязгаарын чийг 0.255
- Имрэгдлийн хязгаарын чийг 0.166
- Уян налархайн үзүүлэлт 0.089
- Хувийн жин 2.72 г/см^3
- Эзэлхүүн жин 2,19 г/см^3
- Хэлхээдсийн эзэлхүүн жин 2,02 г/см^3
- Сүвшил 25,55%
- Сүвшлийн итгэлцүүр 0.344
- Чийглэгийн зэрэг 0.66
- Консистенц <0

Шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрсний хатуулгийн зэрэг-IV.

д/ Хайргархаг шавранцар ул хөрс: /ИГЭ-3/

Бор шаргалаас цайвар саарал өнгөтэй, нуур пролювийн гаралтай, дөрөвдөгчийн настай, хатуу консистенцитэй хайргархаг шавранцар ул хөрс нь судлагдсан талбайн сумын төвийн баруун хэсгээр элбэг тархсан байна. */Инженер-геологийн зүсэлт үз./*

Энэ хөрсний дээжүүдэд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнгээс үзвэл мөхлөг бүтцийн бүрэлдэхүүнд нь:

- Хайрган хэсэг 35,6%
- Элсэн хэсэг 27,9%
- Тоосорхог хэсэг 18,5%
- Шаварлаг хэсэг 18,1% тус тус агуулагдана.

Хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүд нь:

- Байгалийн чийг 0.108
- Урсалтын хязгаарын чийг 0.276
- Имрэгдлийн хязгаарын чийг 0.169
- Уян налархайн үзүүлэлт 0.107
- Хувийн жин 2.72 г/см^3
- Эзэлхүүн жин 2,12 г/см^3
- Хэлхээдсийн эзэлхүүн жин 1.92 г/см^3
- Сүвшил 29,62%
- Сүвшлийн итгэлцүүр 0.422
- Чийглэгийн зэрэг 0.69
- Консистенц <0

Хайргархаг шавранцар ул хөрсний хатуулгийн зэрэг-III.

е/ Хайрга агуулсан шавар ул хөрс: /ИГЭ-4/

Бор шаргалаас цайвар саарал өнгөтэй, нуур пролювийн гаралтай, дөрөвдөгчийн настай, хатуу консистенцитэй хайрга агуулсан шавар ул хөрс нь цооног №16-д хайргархаг шавранцар ул хөрсний дороос илэрч 3,0 метр хүртэл өрөмдөхөд нэвтрээгүй үргэлжилсэн тархалттай байна. */Инженер-геологийн зүсэлт үз./* Энэ хөрсний дээжүүдэд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнгээс үзвэл мөхлөг бүтцийн бүрэлдэхүүнд нь:

- Хайрган хэсэг 18,5%
- Элсэн хэсэг 27,2%
- Тоосорхог хэсэг 16%
- Шаварлаг хэсэг 38,3% тус тус агуулагдана.

Хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүд нь:

- Байгалийн чийг 0.150
- Урсалтын хязгаарын чийг 0.377
- Имрэгдлийн хязгаарын чийг 0.176
- Уян налархайн үзүүлэлт 0.201
- Хувийн жин 2.73 г/см^3
- Эзэлхүүн жин 1,82 г/см^3
- Хэлхээдсийн эзэлхүүн жин 1.58 г/см^3
- Сүвшил 42,03%
- Сүвшлийн итгэлцүүр 0.725
- Чийглэгийн зэрэг 0.56
- Консистенц <0

Хайрга агуулсан шавар ул хөрсний хатуулгийн зэрэг-IV.

Материалын карьер, түүний шинж чанар:

Замын далан байгуулах болон асфальт, бетон хийцийн хольц, чулуу, хайрган материалуудын карьерыг олж нөөцийг тогтоох зорилгоор Даланзадгад сумын төвөөс урагш Номгон сумруу гарах хэсэгт буюу сумын төвөөс 5,0 км орчим зайд чулуу ба хайрган материалд ашиглаж болохоор 2 карьерыг сонгож материалын шинжилгээнд хайрганы 1, чулууны 1 дээжлэлт хийв.

Карьер № 1. Чулуу

GPS-н байршил нь: 43°31'50.12"N 104°27'43.30"E

Материалын шинжилгээнд зориулж авсан дээжийн жин чулуунд 30 кг

Карьерт ашиглах боломжтой талбай: 100х 100м -10 000м^2

Талбайн хэмжээнээс шалтгаалан хүрэлцээтэй нөөц ашиглах боломжтой.

Шинжилгээний үр дүнг товч дурьдвал:

Дайрганы шинжилгээний дүн:

Хүснэгт №12

Шинжилгээний аргын стандарт	Шинжилсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	Техникийн шаардлага	Үр дүн
MNS BS 812 112: 2003	Цохилттой бутрагдалт	%	<25	7,58
MNS ASTM C535:2003	Элэгдэх чанар	%	<25	9,56

MNS 2998-2009	Бутрамтгай чанар /цилиндрт/	%	<15	2,82
MNS 2998-2009	Чулууны марк		600-1200	1200
MNS 2998-2009	Ус шингээлт	%	<2	0,465
MNS 2998-2009	Ширхэгийн дундаж нягт	г/см^3	>2,4	2,64

- **Чулууны бутрагдалтын хэмжээ: /ЧБХ/**

  Гэнэтийн цохиолт болон нөлөөлөлд үзүүлэх дүүргэгчийн эсэргүүцлийг харьцангуй утгыг ЧБХ тодорхойлдог. ЧБХ-г тодорхойлох зорилгоор шинжилсэн дээжийн ЧБХ нь 7.58% байгаа нь техникийн шаардлагыг хангаж байна.

- **Чулууны элэгдлийг тодорхойлох: /ЧЭТ/**

  ЧЭТ арга нь замд хэрэглэх чулуун дүүргэгч материалын хатуулгийг тогтооход түгээмэл хэрэглэгддэг арга юм. Шинжилсэн дээжийн элэгдлийн хэмжээ нь 9.56 % байгаа нь эдгээр материалыг буталсан чулуун суурь болон асфальт бетон хучилтын үед ашиглах боломжтойг баталж байна.

- **Хувийн жин:**

  Шинжилгээ хийсэн дээжийн хувийн жин 2,64 г/см^3 байгаа нь хэвийн үзүүлэлт бөгөөд лабораторид шинжлүүлсэн чулуу нь 1200 маркийн чулуу байна. Тус чулууг цемент бетон болон асфальтобетонд ашиглахад тохиромжтой гэж үзэж байна. */Шинжилгээний үр дүнг тайланд хавсаргав/.*

- **Ус шингээлт:**

  Ус шингээлт нь 0,465 байгаа нь зөвшөөрөгдөх 2 %-иас бага байгаа нь чулуулгийг замын хучилт болон суурь үед ашиглахад тохиромжтой.

Карьер № 2. Хайрга

GPS-н байршил нь: 43°31'50.12"N 104°27'43.30"E

Материалын шинжилгээнд зориулж авсан дээжийн жин чулуунд 30 кг

Карьерт ашиглах боломжтой талбай: 100х 100м -10 000м^2

Талбайн хэмжээнээс шалтгаалан хүрэлцээтэй нөөц ашиглах боломжтой.

Шинжилгээний үр дүнг товч дурьдвал:

Дайрганы шинжилгээний дүн:

Хүснэгт №13

Шинжилгээний аргын стандарт	Шинжилсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	Техникийн шаардлага	Үр дүн
MNS BS 812 112: 2003	Цохилттой бутрагдалт	%	<25	16,92
MNS ASTM C535:2003	Элэгдэх чанар	%	<25	14,26
MNS 2998-2009	Бутрамтгай чанар /цилиндрт/	%	<15	7,23

MNS 2998-2009	Чулууны марк		600-1200	1200
MNS 2998-2009	Ус шингээлт	%	<2	0,180
MNS 2998-2009	Ширхэгийн дундаж нягт	г/см^3	>2,4	2,63

- **Чулууны бутрагдалтын хэмжээ: /ЧБХ/**

  Гэнэтийн цохиолт болон нөлөөлөлд үзүүлэх дүүргэгчийн эсэргүүцлийг харьцангуй утгыг ЧБХ тодорхойлдог. ЧБХ-г тодорхойлох зорилгоор шинжилсэн дээжийн ЧБХ нь 16,9% байгаа нь техникийн шаардлагыг хангаж байна.

- **Чулууны элэгдлийг тодорхойлох: /ЧЭТ/**

  ЧЭТ арга нь замд хэрэглэх чулуун дүүргэгч материалын хатуулгийг тогтооход түгээмэл хэрэглэгддэг арга юм. Шинжилсэн дээжийн элэгдлийн хэмжээ нь 14,26 % байгаа нь эдгээр материалыг буталсан чулуун суурь болон асфальт бетон хучилтын үед ашиглах боломжтойг баталж байна.

- **Хувийн жин:**

  Шинжилгээ хийсэн дээжийн хувийн жин 2,63 г/см^3 байгаа нь хэвийн үзүүлэлт бөгөөд лабораторид шинжлүүлсэн чулуу нь 1200 маркийн чулуу байна. Тус чулууг цемент бетон болон асфальтобетонд ашиглахад тохиромжтой гэж үзэж байна. */Шинжилгээний үр дүнг тайланд хавсаргав/.*

- **Ус шингээлт:**

  Ус шингээлт нь 0,180 байгаа нь зөвшөөрөгдөх 2 %-иас бага байгаа нь чулуулгийг замын хучилт болон суурь үед ашиглахад тохиромжтой.

  /Шинжилгээний үр дүнг тайланд хавсаргав/.

6.6. Товч дүгнэлт

1. Судлагдсан трасс нь засаг захиргааны нэгжийн хуваариар Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутаг дэвсгэрт байрлах ба сумын төвийн авто зам, дугуйн зам, авто зогсоол гэсэн хэсгээс бүрдэнэ.
2. Судалгааны талбайн цаг уурын нөхцөлийг Монгол улсын Барилгын норм ба дүрэм “Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл” АЗУАГН 2.01.01-2004-д заасны дагуу тодорхойлов.
3. Судлагдсан трассын дагуух инженер-геологийн судалгаанд зориулж 2,0-6,0 метрийн гүнтэй 26 цооног өрөмдөхөд сумын төвийн урд хэсэгт өрөмдсөн цооног № 9-д хөрсний ус 5,0 метрийн гүнд илэрсэн байна. */2019 оны 4-р сарын байдлаар/*
4. Судлагдсан талбай нь инженер-геологийн дунд зэргийн төвөгтэй нөхцөлтэй. Энэ нь судалгааны талбайн урд хэсэгт хөрсний ус 5,0 метрийн гүнд илэрсэн, трассын дагууд болон зогсоолын талбайд нөлөөлөхүйц физик геологийн үйл явц үзэгдлийн нөлөө бага ч хүчтэй овойлт үүсгэх шинж чанартай шаварлаг хөрс тархсан, мөн талбайн угаалт явагддаг зэрэг нь инженер-геологийн дунд зэргийн төвөгтэй нөхцөлийг бүрдүүлнэ.
5. Судалгааны талбайд улирлын хөлдөлтийн бүсэд тархсан ул хөрсний хатуулгийн зэрэг, цахилгаан эсэргүүцлийг нормын дагуу тооцож өгвөл:

Хүснэгт №14

ИГЭ-ийн дугаар	Хөрсний нэр төрөл	Ул хөрсний хатуулгийн зэрэг	Хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл
ИГЭ-1	Хайрга агуулсан шавранцар	II	30-70 Ом/м

ИГЭ-2	Шавранцараар чигжигдсэн хайрга	IV	70-120 Ом/м
ИГЭ-3	Хайргархаг шавранцар	III	70-120 Ом/м
ИГЭ-4	Хайрга агуулсан шавар	IV	5-10 Ом/м

6. Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл АЗУАГН.01.01-2004 –н дагуу буурь хөрсний механик шинж чанарын норматив тооцооны үзүүлэлтүүдийг хүснэгтэд үзүүлэв Хүснэгт №15

ИГЭ-ийн дугаар	Хөрсний нэр төрөл	Автозамын ажлын үед ашиглагдах хөрсний ангилал /27-р хүснэгт/	Замын холбооослог ул хөрсний тооцооны үзүүлэлтүүд /19-р хүснэгт/			Хөрсний хөлдөлтийн норматив гүн /4б-р хүснэгт/	Хөлдөх үеийн овойлтын /31-р хүснэгт/		
			$E_{хөрс}$ МПа	$\varphi_{хөрс}$ град	$C_{хөрс}$ МПа	III А	Хөрсний бүлэг	Овойлтын зэрэг	Харьцангуй овойлт %
ИГЭ-1	Хайрга агуулсан шавранцар	Хөнгөн тоосорхог шавранцар	108	32	0,045	2,2	III	Овойлттой	4-7
ИГЭ-2	Шавранцараар чигжигдсэн хайрга	Хайргархаг том ширхэглэлтэй элс	130	42	0,005	3,2	I	Овойлтгүй	≤1
ИГЭ-3	Хайргархаг шавранцар	Хөнгөн тоосорхог шавранцар	108	32	0,045	2,2	III	Овойлттой	4-7
ИГЭ-4	Хайрга агуулсан шавар	Тоосорхог шавар	108	32	0,045	2,2	IV	Хүчтэй овойлттой	7-10

7. Судалгааны талбай нь газар чичирхийллийн 6-7 баллын бүсэд оршино. “Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл” АЗУАГН 2.01.01-2004-д заасны дагуу тодорхойлов.

Зөвлөмж:

Замын далан байгуулах болон асфальт, бетон хийцийн хольц, чулуу, хайрган материалуудын карьерыг олж нөөцийг тогтоох зорилгоор Даланзадгад сумын төвөөс Номгон сумруу гарах хэсэгт буюу сумын төвөөс урагш 5,0 км орчим зайд чулуу ба хайрган материалд ашиглаж болохоор 2 карьерыг сонгож материалын шинжилгээнд хайрганы 1, чулууны 1 дээжлэлт хийсэн бөгөөд шинжилгээний хариунаас үзвэл чулууны карьер болон хайрганы карьер нь цемент бетон болон асфальтобетонд ашиглахад тохиромжтой, техникийн шаардлагыг хангаж байна.

БҮЛЭГ 7: АВТО ЗАМ ТӨСӨЛЛӨЛТ

7.1. Стандарт норм:

Хайгуул судалгааны материалуудыг үндэслэн 2019 оны 5-6-р саруудад суурин боловсруулалтын ажлыг хийв.

Тухайн замыг төсөллөхдөө “Авто зам төсөллөх” ЗЗБНбД 22-004-2016 нормын “Хотын зах болон гэр хороолол, орон нутгийн тосгоны гудамж зам” бүлгийг ашиглав. Стандарт нормд заасан үзүүлэлтүүд нь дараах байдалтай байна.

Тооцоот хурд[i]: *хүснэгт 7-1*

Замын төрөл	Тооцоот хурд, км/ц
Хотын зах болон гэр хороолол, орон нутгийн тосгоны гудамж зам	30 - 50

Хөндлөн огтлолын параметр[ii]: *хүснэгт 7-2*

Замын төрөл	Хөдөлгөөний зурвас, м		Хөдөлгөөний зурвасын сонгосон өргөн, м
	Тоо	Өргөн	
Хотын зах болон гэр хороолол, орон нутгийн тосгоны гудамж зам	1-2	3,0-3,3	3,0

Хэвтээ ба босоо муруйн хамгийн бага үзэгдэх зай[iii]: хүснэгт 7-3

Тооцоот хурд, км/ц	Хамгийн бага үзэгдэх зай, м	Нэг төвшний уулзвар дээрх үзэгдэх зай, м
20	15	20
30	25	25
40	35	30

7.2. Авто зам талбайн төлөвлөлт:

Ажлын даалгавар болон гэрээнд заасны дагуу дараах хэсгүүдэд хуваж, зам, зогсоолын талбайн төлөвлөлтийг хийж гүйцэтгэлээ.

	Хэсгийн нэр:	Хүчин чадал[iv]
	Авто зам:	
1	3-р сургуулийг тойрсон авто зам	400м
2	23-р цэцэрлэгийн урд авто зам	450м
3	Гаалийн хорооны авто зам	530м
4	Дугуйн зам	1190м
	Зогсоолын талбай:	

[i] - Бүлэг11-468. Зүйл 11,3,1
[ii] - бүлэг11-471. Зүйл 11,3,4
[iii] - Бүлэг11-457. Хүснэгт 11,5
[iv] - зөвхөн асфальтбетон хучилттай зорчих хэсгийн талбайгаар тооцов.

1.	НУО-ы арын зогсоол	2520м2
2.	Шинэ ХЖТ-ын зогсоол	14100м2
3.	Авто тээврийн зогсоол	1070м2
4.	БОЭТ-ийн зогсоол	1120м2
5.	5-р сургуулийн зүүн талын зогсоол	1940м2
6.	1-р цэцэрлэгийн зогсоол	840м2
7.	23-р цэцэрлэгийн хойд талын зогсоол+холбоос зам	820м2
8.	24-р цэцэрлэгийн зүүн талын зогсоол	900м2
9.	25-р цэцэрлэгийн урд талын зогсоол	2050м2
10.	Худалдааны төвийн зүүн талын зогсоол	780м2
11.	Ус давуулах далан	50м

Төслийн авто зам, зогсоолын талбай нь хот, суурингийн барилгажсан бүсд байрлах тул тээврийн хөдөлгөөн болон төлөвлөлтийн нөхцөл хүнд, газар орон нутгийн хувьд тэгшивтэр тал. Гадаргуугийн ус зайлуулалт муу, газар доорх болон дээрх шугам сүлжээний байгууламж ихтэй.

7.3. Зам, талбайн байршил, трасс

7.3.1. Авто замууд:

1. **3-р сургуулийг тойрсон авто зам:**

- Зорчих хэсгийн өргөн 6м
- Нийт урт 400м
- Явган замын өргөн тал тус бүрдээ 1,5м
- Зорчих хэсгийн 2 талаар замын босоо хашлагатай
- Явган замын хашлагатай.
- Авто замын нэг талаар гэрэлтүүлэгтэй.
- Замын эхний пк0+00 – пк2+08 хүртэлх хэсэгт нэг талаараас борооны ус зайлуулах далд шугамтай.
- Пк2+08-аас төгсгөл хүртэлх хэсэгт 20-30м тутамд борооны усыг хөндлөн гаргах бетон сувагтай.

Замын зорчих хэсгийн хөндлөн хэвгий нэг тал руугаа 1,5%, явган замын хөндлөн хэвгий 1% байна.

3-р сургуулийн хойд талын зам
ПК2+08 – ПК3+86
3-р сургууль
3-р сургуулийн баруун талын зам
ПК0+00 – ПК2+08

1475
1474
1473
1472
1471
С
З
В
Ю
-90
-60
30
60
90
312 313 314 315 316

Замын трасс нь газар доорх инженерийн шугам сүлжээтэй огтлолцсон. Шугам сүлжээний худгийг өндөрлөх ажлыг тоо хэмжээ, төсөвт тусгасан.

2. 23-р цэцэрлэгийн урд зам

- Зорчих хэсгийн өргөн 6м
- Нийт урт 450м
- Явган замын өргөн тал тус бүрдээ 1,5м
- Зорчих хэсгийн 2 талаар замын босоо хашлагатай
- Явган замын хашлагатай.
- Авто замын нэг талаар гэрэлтүүлэгтэй.
- Трассын төгсгөл хүртэлх хэсэгт 20-30м тутамд борооны усыг хөндлөн гаргах бетон сувагтай.

Замын зорчих хэсгийн хөндлөн хэвгий хоёр тал руугаа 1,5%, явган замын хөндлөн хэвгий 1% байна.





Замын трасс нь газар доорх инженерийн шугам сүлжээтэй огтлолцсон. Мөн айлын хашааны орсон хэсэгт газар чөлөөлөлт хийгдэнэ. Шугам сүлжээний худгийг өндөрлөх ажлыг тоо хэмжээ, төсөвт тусгасан.

3. Гаалийн хорооны авто зам

- Зорчих хэсгийн өргөн 6м
- Нийт урт 530м
- Явган замын өргөн тал тус бүрдээ 1,5м
- Зорчих хэсгийн 2 талаар замын босоо хашлагатай
- Явган замын хашлагатай.
- Авто замын нэг талаар гэрэлтүүлэгтэй.
- Трассын төгсгөл хүртэлх хэсэгт 20-30м тутамд борооны усыг хөндлөн гаргах бетон сувагтай.

Замын зорчих хэсгийн хөндлөн хэвгий 2 тал руугаа 1,5%, явган замын хөндлөн хэвгий 1% байна.


ГАЛАЙНЫ ХОРООНЫ АВТО ЗАМ ПК0+00 – ПК5+26

С
З
В
Ю
1487
1484
-90
-60
-30
0
60



	X, м	Y, м
Ю	4823897.551	453627.982
Ю	4823904.674	453634.976
Ю	4823913.033	453640.439
Ю	4823921.146	453646.256
Ю	4823928.179	453653.360
Ю	4823935.078	453660.600
Ю	4823941.976	453667.839
Ю	4823948.874	453675.079
Ю	4823956.294	453681.731
Ю	4823965.596	453685.218
Ю	4823975.521	453684.807
Ю	4823984.911	453681.408
Ю	4823994.825	453680.793
Ю	4824004.196	453684.086
Ю	4824011.906	453690.422
Ю	4824017.826	453695.803



Гаалийн хорооны замын пк1+70-аас пк2+40 хүртэлх хэсэгт хэвтээ муруйн эргэлтийн радиус бага, үзэгдэх орчин ихээхэн хязгаарлагдмал тул Захиалагч байгууллага газар чөлөөлөлтийг авто замын 2 талын хашлаганаас гадагш 15м хүртэл зайд чөлөөлж өгөх хэрэгтэй.

Захиалагч байгууллагаас өгсөн үүргийн дагуу Трасс нь Гаалийн хорооны хашаан дундуур дайран гарсан. Иймд энэ хэсгийн газар чөлөөлөлтийг Захиалагч байгууллага зохион байгуулах ба чулуун хашааг буулгах ажлыг төсөвт тооцсон.

Замын трасс нь газар доорх инженерийн шугам сүлжээтэй огтлолцсон. Мөн айлын хашааны хэсэг орсон учраас газар чөлөөлөлт хийгдэнэ. Шугам сүлжээний худгийг өндөрлөх ажлыг тоо хэмжээ, төсөвт тусгасан.

4. Дугуйн зам

- Дугуйн замын өргөн 2,5м.
- Нийт урт 1190м
- Хуучин авто замд босоо хашлага хийнэ.
- Дугуйн замын 2 талаар хашлагатай.
- Авто замд 20-30м тутамд борооны усыг хөндлөн гаргах бетон сувагтай.

Дугуйн замын хөндлөн хэвгий 1 тал руугаа 1,5% байна.



7.3.2. Зогсоолын талбай:

1. Нутгийн удирдлагын ордны арын зогсоол

- Авто зогсоолын хэмжээ 2520м2 буюу 104ш автомашины зогсоолтой.
- Нэг машины зогсоолын хэмжээ 5х2,5м
- Зогсоолыг тойруулан босоо хашлагатай
- Зогсоолыг тойрон 1-2,5м өргөн явган замтай, Явган замын хашлагатай.
- Зогсоолыг тойрсон гэрэлтүүлэгтэй.
- Ус тунах борооны усыг хөндлөн гаргах бетон сувагтай.

Талбайн хөндлөн хэвий нь 0,5-1,5%, явган замын хөндлөн хэвгий 1% байна.

Төслийн зогсоолын талбай
Нүтгийн удирдлагын ордон


С
З
В
Ю

76.45 м
А хэсэг
Б хэсэг
Зүүн тал 32.00 м
Баруун тал 32.00 м
Т

Одоо байгаа хөшөө, обьектыг буулгах, инженерийн байгууламжийг буулгах, өргөх ажлын хэмжээг тоо хэмжээ болон төсөвт оруулсан.

2. Шинэ ХЖТ-ын зогсоол

- Авто зогсоолын хэмжээ 14100м2 буюу 441ш автомашины зогсоолтой.
- Нэг машины зогсоолын хэмжээ 5х2,5м
- Зогсоолыг тойруулан босоо хашлагатай
- Зогсоолыг тойрон 1,5м өргөн явган замтай, Явган замын хашлагатай.
- Зогсоолыг тойрсон гэрэлтүүлэгтэй.
- Борооны усыг зайлуулах далд шугам төлөвлөсөн.

Шинэ ХЖТ-ын зогсоолын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулсан.

3. Авто тээврийн урд талын зогсоол

- Авто зогсоолын хэмжээ 1070м2 буюу 11ш автомашин, 5ш том оврын автобусны зогсоолтой.
- Нэг машины зогсоолын хэмжээ 5х2,5м, автобусны зогсоолын хэмжээ 4х12м
- Зогсоолыг тойруулан босоо хашлагатай
- Зогсоолыг тойрон 1,5м өргөн явган замтай, Явган замын хашлагатай.
- Зогсоолыг тойрсон гэрэлтүүлэгтэй.

Шинээр тээврийн хэрэгсэл болон автобусны зогсоол, мөн орц гарц төлөвлөж өгсөн.



4. Бусийн оношлогоо, эмчилгээний төвийн урд талын зогсоол

- Авто зогсоолын хэмжээ 1120м2 буюу 37ш автомашины зогсоолтой.
- Нэг машины зогсоолын хэмжээ 5х2,5м
- Зогсоолыг тойруулан босоо хашлагатай
- Зогсоолыг тойрон 1,5м өргөн явган замтай, Явган замын хашлагатай.
- Зогсоолыг тойрсон гэрэлтүүлэгтэй.

Шинээр тээврийн хэрэгсэл болон автобусны зогсоол, мөн орц гарц төлөвлөж өгсөн.

Бусийн оношлогоо эмчилгээний төвийн зогсоол
ХУУЧИН ЗАМ

С
З
В
Ю


Хуучин зам

5. 5-р сургуулийн зүүн талын зогсоол

- Авто зогсоолын хэмжээ 1940м2 буюу 72ш автомашины зогсоолтой.
- Нэг машины зогсоолын хэмжээ 5х2,5м
- Зогсоолыг тойруулан босоо хашлагатай
- Зогсоолыг тойрон 1,5м өргөн явган замтай, Явган замын хашлагатай.
- Зогсоолыг тойрсон гэрэлтүүлэгтэй.
- Борооны усыг зайлуулах далд байгууламж хийнэ

Зогсоолын талбайн газар доор өндөр хүчдэлийн кабель байгаа учраас Гүйцэтгэгч анхаарч ажиллах хэрэгтэй.



Захиалагч байгууллагаас 5-р сургуулийн зүүн талд зогсоол төлөвлөх даалгавар өгсөн боловч Цахилгаан түгээх ТӨХК-иас Техникийн нөхцөл олгогдохгүй, зам талбайн ажил явуулахыг зөвшөөрөхгүй гэж мэдэгдсэн.

6. 1-р цэцэрлэгийн урд талын зогсоол

- Авто зогсоолын хэмжээ 840м2 буюу 26ш автомашины зогсоолтой.
- Нэг машины зогсоолын хэмжээ 5х2,5м
- Зогсоолыг тойруулан босоо хашлагатай
- Зогсоолыг тойрон 1,5м өргөн явган замтай, Явган замын хашлагатай.
- Зогсоолыг тойрсон гэрэлтүүлэгтэй.

Зогсоолын талбайн голд байгаа нам хүчдэлийн шонг шилжүүлэх арга хэмжээ авна.

7. 23-р цэцэрлэгийн арын зогсоол

- Орох замын урт 75м, Авто зогсоолын хэмжээ 820м2 буюу 36ш автомашины зогсоолтой.
- Нэг машины зогсоолын хэмжээ 5х2,5м
- Зогсоолыг тойруулан босоо хашлагатай
- Зогсоолыг тойрон 1,5м өргөн явган замтай, Явган замын хашлагатай.
- Зогсоолыг тойрсон гэрэлтүүлэгтэй.







8. 24-р цэцэрлэгийн зүүн талын зогсоол

- Авто зогсоолын хэмжээ 900м2 буюу 36ш автомашины зогсоолтой.
- Нэг машины зогсоолын хэмжээ 5х2,5м
- Зогсоолыг тойруулан босоо хашлагатай
- Зогсоолыг тойрон 1,5м өргөн явган замтай, Явган замын хашлагатай.

Зогсоолыг тойрсон гэрэлтүүлэгтэй.

9. 25-р цэцэрлэгийн урд талын зогсоол

- Авто зогсоолын хэмжээ 2050м2 буюу 83ш автомашины зогсоолтой.
- Нэг машины зогсоолын хэмжээ 5х2,5м
- Зогсоолыг тойруулан босоо хашлагатай
- Зогсоолыг тойрон 1,5м өргөн явган замтай, Явган замын хашлагатай.

Зогсоолыг тойрсон гэрэлтүүлэгтэй. Орц гарц шинээр төлөвлөсөн.

10. Худалдааны төвийн зүүн талын зогсоол

- Авто зогсоолын хэмжээ 780м2 буюу 29ш автомашины зогсоолтой.
- Нэг машины зогсоолын хэмжээ 5х2,5м
- Зогсоолыг тойруулан босоо хашлагатай
- Зогсоолыг тойрон 1,5м өргөн явган замтай, Явган замын хашлагатай.

Зогсоолыг тойрсон гэрэлтүүлэгтэй. Орц гарц шинээр төлөвлөсөн.

11. Ус давуулах далан

- Ус давуулах далангийн урт 50м
- Цементбетон хучилттай, хажуу налуу бэхэлгээтэй. .
- Ус угаагдахаас сэргийлсэн тулц бетон, рисберм хийнэ.

Ус дамжуулах далан


С
З
В
Ю
1480
1477
-60
-30
0
30
60
90


Трассын цэгүүдийн координат

7.4. Хучилтын бүтээц.

Зам, талбайн хучилтыг дараах байдлаар төсөллөсөн.

Авто зам болон зогсоол:

1. Асфальтбетон хучлага h=50мм
2. Цементээр бэхжүүлсэн суурь h=200мм
3. Зохистой ширхэглэлтэй хайрган суурь 200мм





Явган зам:

1. Явган замын хавтан h=60мм
2. Цементээр бэхжүүлсэн суурь 150мм

Дугуйн зам:

1. Асфальтбетон хучлага h=50мм
2. Цементээр бэхжүүлсэн суурь h=150мм



Давуулах далан:

1. Цеменбетон хучлага 200мм
2. Буталсан чулуун суурь 300мм



Хучилтын тооцооны схем:

Исходные данные			
Название объекта	Даланзадгад, зам талбай		
Район проектирования			
Выполняемые расчёты	На упругий прогиб, сдвиг, изгиб, стат. нагрузку, морозоустойчивость		
Техническая категория дороги	IV категория	Дорожно-климатическая зона	IV
Тип дорожной одежды	Капитальный	Схема увлажнения	Схема 1
Число полос движения (в обе стороны)	2	Коэффициент уплотнения грунта	1.02
Номер расчётной полосы от обочины	1	Суммарное число приложений нагрузки	24031
Уклоны в местах перелома профиля, ‰	—	Расчётное количество дней в году Трдг	140
Расчётная влажность грунта Wp	0.60	Расчётный срок службы Тсл, лет	15
Нагрузка, кН / Давление, МПа / D штампа, см	100 / 0.60 / 37		
Заданная надёжность Кн	0.80	Глубина промерзания грунтов, м	3.04

Состав транспортного потока

№	Транспортное средство	Интенсивность движения авт/сут	Коэффициент приведения	Приведённая интенсивность
1	Легковые автомобили	100	0	0
2	Лёгкие грузовые автомобили грузоподъёмностью от 1 до 2 т	50	0.005	0.25
3	Тяжёлые грузовые автомобили грузоподъёмностью от 5 до 8 т	1	0.7	0.7
4	Автобусы	5	0.7	3.5
5	Двухосные грузовые автомобили	5	1.11	5.55
6	Автобусы	5	1.46	7.3
Итого		166		17.3

Показатель изменения интенсивности	1.04
